



# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 05 сарын 23 өдөр


Төрийн ордон, Улаанбаатар хот

## САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд 2013 оны 12 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан "Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр"-ийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.



3.ЭНХБОЛД



## САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭР

### УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ, ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Талууд

Энэхүү Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг 2013 оны 12 дугаар сарын 09-ний өдөр Монгол Улс ба Азийн Хөгжлийн Банк (АХБ) хооронд байгуулав.

ОШСЗШ-аар  
хэрэгжүүлэх хөрөнгө  
оруулалтын  
хөтөлбөр

Монгол Улсыг төлөөлж Монгол Улсын Засгийн газар (Засгийн газар) "Улаанбаатар хотын нийтийн аж ахуйн үйлчилгээ болон гэр хорооллыг<sup>1</sup> хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр" (Хөтөлбөр)-ийг Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө"-тэй уялдуулан хэрэгжүүлэх үүрэг амлалт хүлээж байна. Хөтөлбөр болон ерөнхий төлөвлөгөөг энэхүү Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн Хуваарь 1-д тодорхойлов.

Хөтөлбөрийг 2014-2023 онд хэрэгжүүлэх зардлын нийт төсөв 320 сая ам.доллар байна.

Олон шатлалт  
санхүүжилтийн  
зээлийн шугам

Олон шатлалт санхүүжилтийн зээлийн шугам (Зээлийн шугам) нь хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих төслүүдийг санхүүжүүлэхэд зориулагдах бөгөөд тухайн төслүүд нь энэхүү Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрт тусгагдсан ойлголцлууд болон Хуваарь 4-т заасан шалгууруудыг тус тус хангасан байна.

Төсөл тус бүр дараахь үйл ажиллагааг хамарч болно. Үүнд:

- (i) дэд төвүүдийн доторх авто зам болон хотын үйлчилгээг өргөтгөх, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах,
- (ii) зорилтот хэсгүүд дэх эдийн засгийн болон дэд бүтцийн үйлчилгээг нэмэгдүүлэх;
- (iii) үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх;
- (iv) хот байгуулалтын хөтөлбөрийн менежмент, үйлчилгээг хүргэх чиглэлээр институцийг бэхжүүлж, чадавхийг бүрдүүлэх.

Энэхүү Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр нь аливаа санхүүжилт амлах хууль зүйн үүргийг АХБ-нд хүлээлгэхгүй. АХБ нь Засгийн газраас гаргасан санхүүжилт авах тухай аливаа хүсэлтээс татгалзах, Зээлийн шугамын ашиглагдаагүй хэсгийг цуцлах болон Зээлийн шугамын шатлалын санхүүжилтийг авах Засгийн газрын эрхийг цуцлах асуудлыг дангаараа, үндэслэлтэйгээр хэрэгжүүлэх эрхтэй. Зээлийн шугамыг нээх үндэслэл болсон, энэхүү Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрт тусгагдсан ерөнхий ойлголцол, үйлчилгээд нөлөөлдөг байдал нийцэж байвал АХБ үе шатны санхүүжилтийг олгож болно.

<sup>1</sup>Уламжлалт гэр сууц.

Гарын үсэг /Signature/

2019 оны 2 сарын 21 өдөр  
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia  
OFFICIAL TRANSLATION

Энэхүү Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр нь аливаа санхүүжилт авах хүсэлт гаргах үүргийг Засгийн газарт хүлээлгэхгүй. Засгийн газар нь Зээлийн шугамаас аливаа санхүүжилт авах хүсэлт гаргахгүй байх эрхтэй. Түүнчлэн Засгийн газар нь хэдийд ч Зээлийн шугамын аливаа ашиглагдаагүй хэсгийг цуцлах эрхтэй байна.

Засгийн газар болон АХБ нь Зээлийн шугам, түүний аливаа ашиглагдаагүй хэсгийг цуцлах тус тусын эрхийг хэрэгжүүлж болох агаад АХБ нь бусад талуудад бичгээр мэдэгдэл өгснөөр санхүүжилт авах тухай хүсэлтийг татгалзах эрхээ хэрэгжүүлж болно. Уг бичгээр өгөх мэдэгдэлд хүсэлтийг цуцлах, эсхүл татгалзах болсон үндэслэл тайлбарыг тусгах бөгөөд хүсэлтийг цуцалсан тохиолдолд цуцлалт хүчин төгөлдөр болох огноог заасан байна.

### Санхүүжилтийн төлөвлөгөө

Хөтөлбөрийн Санхүүжилтийн төлөвлөгөөг дор тоймлон үзүүлэв.

Эх үүсвэр	Хэмжээ (сая ам.дол.)	Нийт дүнд эзлэх хувь (%)
<b>Хөрөнгө оруулалтын хөтөлбөр</b>		
Азийн хөгжлийн банк ОШСЗШ	163.70	51.20
Улаанбаатар хотын захиргаа	96.00	30.00
Хамтарсан санхүүжилт <sup>а</sup>	60.30	18.80
<b>Дүн</b>	<b>320.00</b>	<b>100.00</b>
<b>Төсөл 1</b>		
Азийн хөгжлийн банк		
АХС-ийн зээл	22.50	21.50
ЕСЭУ-ийн зээл	27.50	26.30
ХБОДБС-ХСТС <sup>б</sup> -ийн буцалтгүй тусламж	3.70	3.50
<b>Хэсгийн дүн АХБ</b>	<b>53.70</b>	<b>51.30</b>
Улаанбаатар хотын захиргаа <sup>с</sup>	22.44	21.50
Хамтарсан санхүүжилт	28.38	27.25
<b>Дүн</b>	<b>104.52</b>	<b>100.00</b>

АХБ = Азийн хөгжлийн банк, АХС = Азийн хөгжлийн сан, ОШСЗШ = Олон шатлалт санхүүжилтийн зээлийн шугам, ЕСЭУ = Ердийн сангийн эх үүсвэр, ХБОДБС = Хотын байгаль орчны дэд бүтцийн сан

Тайлбар: Дүнг бүхэлдэж авсан учир нийлбэр дүнтэй яв цав тохирохгүй байж болно.

<sup>а</sup> Европын хөрөнгө оруулалтын банк ус хангамж, ариун цэврийн байгууламжид зориулан 60.30 сая хүртэл ам.доллартай тэнцэх хэмжээний зэрэгцээ санхүүжилтийг (АХБ захиран зарцуулахгүй) ОШСЗШ-д оруулах, үүний дотор Төсөлд 1-д зориулан 28.38 сая ам.доллартай тэнцэх хэмжээний санхүүжилт олгох сонирхлоо илэрхийлсэн. Харъяа ЕХОБ-ны хамтарсан санхүүжилт төлөвлөсний дагуу хэрэгжихгүй нөхцөлд Засгийн газар санхүүжилтийн дутууг олгох шаардлагатай арга хэмжээг авна. **АЛБАН ЕСНЫ ОРЧУУЛГА МӨН**

<sup>б</sup> ХБОДБС = Хотын санхүүжилтийн түншлэлийн сангийн Хотын байгаль орчны дэд бүтцийн сан.

Гарын үсэг /Signature/ .....

2017 оны 1 сарын 26-дөр  
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia  
OFFICIAL TRANSLATION

<sup>6</sup> Үүнд зөвхөн 1-р үе шатны төслийн дотоодын татвар, хураамжийн зардал багтсан бөгөөд эдгээр татвар, хураамжийг Засгийн газар чөлөөлөх замаар хариуцна.

Эх сурвалж: Азийн хөгжлийн банкны хийсэн тооцоо.

## Санхүүжилтийн нөхцөл

Энэхүү хэлэлцээрт тусгагдсан ойлголцуудыг Засгийн газар хангаж байгаа бөгөөд төслүүд нь мөн тэдгээр ойлголцолд нийцэж байгаа нөхцөлд Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих төслүүд бэлэн болсон тухай бүр АХБ тэдгээрийг санхүүжүүлэх зээл, буцалтгүй тусламжийг олгоно. Зээл болон буцалтгүй тусламжууд нь санхүүжилтийн шатлалыг бүрдүүлнэ.

Шатлал тус бүрийг түүний өмнөх, эсхүл удаах шатлалын санхүүжилтийн нөхцлөөс өөр нөхцлөөр санхүүжүүлж болно. Санхүүжилтийн нөхцлийг тухайн төслийн онцлог болоод төслийн санхүүжилтийн шатлалыг хууль ёсны хэлэлцээрээр баталгаажуулах үед хүчин төгөлдөр үйлчилж байгаа АХБ-ны санхүүжилтийн бодлого, журмаас хамааруулан сонгоно. Шатлалуудын санхүүжилтийг ээлж дараагаар, эсхүл зэрэгцүүлэн олгож болох агаад зарим нь цаг хугацааны хувьд давхцаж болно.

Зээлийн шугамд хөрөнгө байршуулсны төлбөр ногдуулахгүй. Гагцхүү АХБ-наас зээл хэлбэрээр бодитой олгосон санхүүжилтэд уг төлбөрийг ногдуулна. Тухайн нэг шатлалын санхүүжилтийг олгох үед хүчин төгөлдөр үйлчилж байгаа АХБ-ны санхүүжилт олгох үүрэг амлалт хүлээхтэй холбоотой журмыг уг шатлалын санхүүжилтэд баримтална.

## Санхүүжилтийн хэмжээ

Зээлийн шугамаас олгох санхүүжилтийн дээд хэмжээ 163.7 сая ам.доллар байна. Уг санхүүжилтийг АХБ-ны ердийн сангийн эх үүсвэр<sup>2</sup>, Тусгай сангийн эх үүсвэрээс<sup>3</sup> болон АХБ захиран зарцуулах хамтарсан санхүүжилтээс үе шаттайгаар олгох бөгөөд ингэхдээ тухайн эх үүсвэрийн хуваарилалт, түүнд хамрагдахад тавигдах шалгуурын талаар тухайн үед мөрдөгдөж байгаа АХБ-ны бодлого, журмыг баримтална.

## Хамтарсан санхүүжилт

Зээлийн шугамтай зэрэгцэн 60.30 сая ам.доллартай тэнцэх хэмжээний санхүүжилт (АХБ захиран зарцуулахгүй) хийгдэнэ. Зээлийн шугамын хүрээнд АХБ-наас захиран зарцуулж олгох хамтарсан санхүүжилтийн хэмжээ 13.70 сая ам.доллар байх

<sup>2</sup> АХБ-ны Ердийн сангийн эх үүсвэрээс олгох LIBOR-т суурилсан зээлд баримтлах, 2001 оны 7 дугаар сарын 1-ний өдөр батлагдсан Ердийн үйл ажиллагааны зээлийн журмын заалтуудыг тэдгээрт холбогдох зээлийн хэлэлцээрээр оруулах өөрчлөлтийн хамт ийм бүх зээлд мөрдөнө.

<sup>3</sup> АХБ-ны Тусгай сангийн эх үүсвэрээс олгох зээлд баримтлах, 2006 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр батлагдсан Тусгай үйл ажиллагааны зээлийн журмын заалтуудыг тэдгээрт холбогдох зээлийн хэлэлцээрээр оруулах өөрчлөлтийн хамт ийм бүх зээлд мөрдөнө.

Гарын үсэг /Signature/ .....  
2017 оны 7 сарын 11 өдөр  
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia  
OFFICIAL TRANSLATION

тооцоотой байна.

### Санхүүжилт хийж дуусах хугацаа

Аливаа шатлалын санхүүжилтийн зарцуулалтыг хийх эцсийн хугацаа 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно. Санхүүжилтийн эцсийн шатлалыг 2018 оны 12 дугаар сарын 31-ний дотор хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

### Нөхцөл, журам

Засгийн газар нь шатлал тус бүрийн санхүүжилтийг Улаанбаатар хотын захиргаа (УБХЗ)-нд дамжуулан зээлдүүлэх ба энэхүү Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр болон тухайн шатлал нэг бүрийн хууль ёсны хэлэлцээрт тусгагдсан нөхцөл, журмын дагуу Хөтөлбөрийн зардлыг санхүүжүүлэхэд ашиглана.

### Хэрэгжүүлэлт

Хэрэгжүүлэгч байгууллага нь Улаанбаатар хотын захиргаа байна. Улаанбаатар хотын захиргаа нь Хөтөлбөрийг энэхүү Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн Хуваарь 1 ба Хуваарь 3-т заасан зарчмууд болон санхүүжилтийн шатлал бүрийн хууль ёсны хэлэлцээрийн хүрээнд тэдгээрт орох нэмэлт нөхцлүүдэд нийцүүлэн хэрэгжүүлнэ.

### Үе шатны санхүүжилтийн хүсэлт

Үе шатны санхүүжилтийн хүсэлт (ҮШСХ)-ийг хүргүүлмэгц Хөтөлбөр болон түүний холбогдох төслүүдийг санхүүжүүлэх зээлийг Зээлийн шугамаас авах хүсэлтийг Монгол Улсын Засгийн газар Эдийн засгийн хөгжлийн яам (ЭЗХЯ), эсхүл түүнийг залгамжлагч байгууллагаар дамжуулан гаргаж болох бөгөөд АХБ тийнхүү олгохыг зөвшөөрч болно. ҮШСХ тус бүрийг ЭЗХЯ хүргүүлнэ. Засгийн газар нь холбогдох үе шатны санхүүжилтийн хүсэлт болон тухайн шатлалын хууль ёсны хэлэлцээрийн дагуу санхүүжилтийн шатлалын хөрөнгөөс Улаанбаатар хотын захиргаанд санхүүжилтийг олгоно. АХБ нь ҮШСХ-ийг хянан үзээд шаардлага хангасан гэж үзвэл холбогдох хууль ёсны хэлэлцээрийг бэлтгэнэ.

ҮШСХ тус бүрийн хүрээнд санхүүжүүлэх санхүүжилтийн шатлалууд нь энэхүү хэлэлцээрийн Хуваарь 4-т тусгагдсан сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтүүдэд нийцсэн, үнэлгээний зохих нөхцөл шаардлагыг хангасан байхаас гадна холбогдох хамгаалалтын арга хэмжээ, санхүүгийн дүрэм журам болон бусад баримт бичгүүдийг бэлтгэсэн байвал зохино. АХБ болон Улаанбаатар хотын захиргаа Зээлийн шугамын удирдлагын баримт бичиг болон шаардлагатай үйл ажиллагааг эхлүүлэх хугацааг Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр байгуулагдсан даруй буюу санхүүжилтийн эхний шатлалын үйлчилгээний хэлэлцээрүүд хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө тохиролцоно.

Хэрэглэгчийн үеэст /Signature/

2022 оны 12 сарын 26-дөр  
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia  
OFFICIAL TRANSLATION

Хэрэгжилтийн хүрээний ерөнхий журам

Зээлийн шугамыг энэхүү хэлэлцээрийн Хуваарь 3-т тусгагдсан хэрэгжилтийн хүрээний дагуу хэрэгжүүлнэ.

Зээлийн шугамын хүрээнд санхүүжүүлэх санхүүжилтийн шатлалуудыг олгоход дор дурдсан журмыг мөрдөнө:

- (i) Засгийн газар ҮШСХ-ийг АХБ-нд хүргүүлэхээсээ өмнө уг ҮШСХ-ийн талаар АХБ-нд урьдчилан мэдэгдэнэ.
- (ii) Засгийн газар ҮШСХ-ийг АХБ-тай тохиролцсон загварын дагуу бэлтгэж хүргүүлнэ.
- (iii) АХБ тухайн нэг санхүүжилтийн шатлалын хууль ёсны хэлэлцээр байгуулах хэлэлцээ хийх, байгуулахаас дангаараа татгалзаж болно.
- (iv) АХБ ҮШСХ-ийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд Талууд хууль ёсны хэлэлцээрийг байгуулах хэлэлцээг хийж, байгуулна.

ҮШСХ-ийн мэдээлэл

ҮШСХ-ийг урьдчилан тохиролцсон загварын дагуу бэлтгэх бөгөөд дараахь өгөгдлийг тусгасан байна:

- (i) зээл, буцалтгүй тусламжийн хэмжээ;
- (ii) санхүүжүүлэх төслийн тодорхойлолт;
- (iii) зардлын тооцоо болон санхүүжилтийн төлөвлөгөө;
- (iv) төсөлтэй холбоотой хэрэгжилтийн зохицуулалт;
- (v) энэхүү хэлэлцээрт тусгагдсан ойлголцлууд хүчинтэй хадгалагдах хийгээд тэдгээрийг биелүүлэхийг нотолсон баталгаажуулалт;
- (vi) өмнөх зээлийн хэлэлцээр болон төслийн хэлэлцээрийн (аль хамаарахын) заалтуудыг биелүүлэхийг нотолсон баталгаажуулалт;
- (vii) Зээлийн шугамын удирдлагын баримт бичгийн дагуу шаардагдах, эсхүл АХБ-наас үндэслэлтэйгээр шаардаж болох бусад мэдээлэл.

Хамгаалалтын арга хэмжээ

Зээлийн шугамыг хэрэгжүүлэх явцад мөрдөх хамгаалалтын арга хэмжээний хүрээг энэхүү Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн Хуваарь 5-д тусгав.

АХБ санхүүжилтийн шатлалыг батлах үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа АХБ-ны хамгаалалтын арга хэмжээний бодлого, журмыг тухайн шатлалын хүрээнд санхүүжих төслүүдэд баримтална.

Худалдан авах ажиллагаа

Зээлийн шугамаас санхүүжих үеийн баримт бичгүүдийг худалдан авах ажиллагааг 2013 онд болон 2014 онд АХБ-ны Худалдан авах ажиллагааны журам (тухай бүр нэмэлт, өөрчлөлт орсон)-ын дагуу явуулна.

Гарын үсэг /Signature/

2014 оны 2 сарын 21 өдөр  
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia  
OFFICIAL TRANSLATION

**Зөвлөх үйлчилгээ**

Зээлийн шугамаас санхүүжих бүх зөвлөх үйлчилгээний худалдан авах ажиллагааг 2013 онд батлагдсан АХБ-ны Зөвлөхийн үйлчилгээний журам (тухай бүр нэмэлт, өөрчлөлт орсон)-ын дагуу явуулна.

**Урьдчилан гэрээ байгуулах, нөхөн санхүүжүүлэх**

Санхүүжилтийн шатлал тус бүрийн хүрээнд АХБ өөрийн бодлого, журамд нийцүүлэн (i) барилгын ажил, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний гэрээг урьдчилж байгуулах; (ii) Зээл болон буцалтгүй тусламж хүчин төгөлдөр болохоос өмнө буюу холбогдох хууль ёсны хэлэлцээрт гарын үсэг зурахаас 12 сараас хэтрэхгүй хугацааны өмнө гарсан, тухайн олгох зээл болон буцалтгүй тусламжийн 20 хувиас үл хэтрэх үнийн дүн бүхий барилгын ажил, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний эрх бүхий зардлыг нөхөн санхүүжүүлэхийг зөвшөөрч болно. Урьдчилсан гэрээ байгуулах болон/эсхүл нөхөн санхүүжилт хийх аливаа зөвшөөрөл олгох нь холбогдох төслийг санхүүжүүлэх үүргийг АХБ-нд хүлээлгэхгүй болохыг Засгийн газарт мэдээлсэн болно.

**Зарцуулалт**

Санхүүжилтийн шатлал бүрийн хүрээнд хийгдэх зарцуулалтыг холбогдох Зээлийн хэлэлцээрт заасан зарцуулалтын нөхцөл журам болон 2012 онд батлагдсан *Зээлийн зарцуулалтын гарын авлага* (тухай бүр нэмэлт, өөрчлөлт орсон)-ын дагуу гүйцэтгэнэ.

**Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнахтай холбоотой зохицуулалт**

Зээлийн шугамын Төлөвлөлт, хяналт шинжилгээний хүрээг энэхүү хэлэлцээрийн Хуваарь 2-т тусгасан бөгөөд хэрэгжилтийн үр дүнг түүний дагуу дүгнэнэ. Хяналт-шинжилгээ болон үнэлгээг энэхүү Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн Хуваарь 3-т заасны дагуу гүйцэтгэнэ. Хөтөлбөр, түүний төслүүдийн гүйцэтгэлийн үнэлгээг АХБ-нд хүргүүлэх хагас жилийн тайланд тусгана.

**Үүрэг амлалт**

Засгийн газрын авсан үүрэг амлалтыг Хуваарь 6-д тусгав.

**МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ**

**АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКИЙГ  
ТӨЛӨӨЛЖ**

Эдийн засгийн хөгжлийн сайд  
Нямжавын Батбаяр

Азийн хөгжлийн банкны Монгол дахь  
суурин төлөөлөгч Роберт Шюелдхаммер

Гарын үсэг /Signature/ .....

20 15 оны 1 сарын 21 өдөр  
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia  
OFFICIAL TRANSLATION

# ХУВААРЬ 1

## ОЛОН ШАТЛАЛТ САНХҮҮЖИЛТИЙН ЗЭЭЛИЙН ШУГАМ

### А. Салбарын ерөнхий төлөвлөгөө

1. Үндэслэл. Гэр хороололд 800,000 гаруй иргэд амьдарч байгаа нь Улаанбаатар хотын хүн амын 60%, улсын нийт хүн амын 30 гаруй хувийг эзэлж байна. Гэр хорооллын амьдрах нөхцөл хүнд. Гэр хорооллын өрхүүд хашаандаа нүхэн жорлон хэрэглэж, хог хаягдлыг цуглуулж зайлуулах асуудал хангалтгүй гэхчлэн ариун цэврийн нөхцөл муу байгаагаас шалтгаалан ихээхэн бохир амьдрах орчныг үүсгэжээ. Агаарын бохирдлын хувьд дэлхийн хэмжээнд хамгийн их бохирдолтой газруудын тоонд орж, айл өрхүүдэд зохистой дулаан хангамжийн тогтолцоо<sup>4</sup> байдаггүй, мөн шороон замтай зэргийн улмаас нэн ялангуяа өвлийн улиралд агаарын бохирдол ихтэй байдаг. Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газраас ус түгээх хугацааг дамжуулан түгээдэг усны хүртээмж хангалтгүй<sup>5</sup> байна. 2011 онд Улаанбаатар хотод 40,000 гаруй иргэд шилжин ирсний дийлэнх нь гэр хороололд суурьшжээ. Ирэх 10 жилд шилжилт хөдөлгөөн болон төрөлттэй холбоотойгоор гэр хорооллын хүн ам 400,000-аар өсөх хандлагатай байна. Хэрэв нөхцөл байдлыг сайжруулахгүй бол энэ нь хотын байгаль орчин болон хүн амын эрүүл мэндэд бодитой аюул учруулах болно.

2. Дэд төвүүдийг сайжруулах стратеги. Гэр хороололд суурьшлын хэлбэр давамгайлах агаад худалдаа үйлчилгээ, захиргааны ойр зуурын үйлчилгээ төвлөрсөн дэд төв хэмээн нэрийдсэн зангилаадтай. Эдгээр дэд төв нь тухайн орон зай болон орон нутгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тийм хэдий ч суурь дэд бүтцийн хангамж муу байгаагаас эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлсээр байна.

3. Нийтийн аж ахуйн үйлчилгээгээр хангаж, төлөвлөлтийг сайжруулан, тэргүүлэх ач холбогдолтой замын дагуух дэд бүтцийн сүлжээг байгуулснаар дэд төвийн суурьшлын хэв шинжийн бүтцийг өөрчлөх ажлыг эхлүүлнэ. Ингэснээр оршин суугчдыг хотын суурь үйлчилгээ болон нийгэм-эдийн засгийн байгууламжаар хангаж, улмаар орон нутгийн эдийн засгийн өсөлтийг дэмжихийн зэрэгцээ оршин суух буюу орон сууцны нөхцлөө сайжруулах<sup>6</sup>, нийтийн эзэмшлийн газарт нэвтрэх боломжийг иргэдэд олгох юм. Гэр хорооллын дэд төвүүд дэх дэд бүтцийг сайжруулж, хотын төв хэсэгтэй холбох нь иргэдэд тэгш боломжийг бүрдүүлж оролцоог хангах, хүн болон бараа бүтээгдэхүүний зорчилт хөдөлгөөнийг хялбаршуулахад ихээхэн чухал юм. Газар ашиглах үйл ажиллагааг өөрчилж, нягтралыг нэмэгдүүлсэнээр суурьшлын бүсэд ус хангамж, ариутгах татуурга, дулаан хангамжийн үйлчилгээ сайжирна<sup>7</sup>.

<sup>4</sup> Ихэнх айл өрх нүүрс түлдэг сайжруулаагүй зуух хэрэглэж байна.

<sup>5</sup> Гэр хорооллын нэг иргэн өдөрт 10 литр ус хэрэглэж байгаа нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжид заасан шаардлагын талыг хангаж байгаа ба гэр хорооллын өрхүүд ус түгээх цэг болон зөөврийн машинаар түгээж буй өртөг өндөртэй усны төлбөрт бусад хэрэглэгчтэй харьцуулахад 2-10 дахин өндөр үнэ төлж байна.

<sup>6</sup> Зорилтот гэр хорооллын өрхүүдийн 60% нь тухайн дэд төвд баригдах инженерийн бүрэн хангамжтай нийтийн орон сууцны байраар газраа солих хувилбарыг авч үзэх төлөвтэй байна.

<sup>7</sup> Өнөөгийн нөхцөлд төвийн цэвэр, бохир ус болон дулааны шугамд тусгайлан хөлбөлт хийлгэх нь өртөг өндөртэй бөгөөд ба ихэнх өрхүүд төлбөрийг төлж хүчрэхээргүй байна. Мөн дэд төвийг хөгжүүлэх зорилтын хүрээнд хашаа бүрт бие даасан системчилсэн холболт хийх нь оновчтой бус бөгөөд энэ нь газар ашиглалтын холимог хэлбэрийг хөгжүүлэх бололцоог бууруулж, нягтрал багасахад хүргэснээр дэд бүтцийн үйлчилгээний өртгийг тогтворжуулахад сөргөөр нөлөөлөх талтай. *Signature* .....

2011 оны 1 сарын 2 өдөр  
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia  
OFFICIAL TRANSLATION



4. Ерөнхий төлөвлөгөө. Гэр хорооллыг дахин төлөвлөж, хөгжүүлэх талаар Засгийн газар болон Улаанбаатар хотын захиргаанаас баримталж буй тэргүүлэх зорилтод тулгуурлан ерөнхий төлөвлөгөөг боловсруулав. Энэхүү төлөвлөгөө нь ажлын байр, орон сууц бүхий эдийн засгийн боломжийг бүрдүүлсэн, агаар, хөрсний бохирдол багатай сайтар хөгжсөн дэд төвүүдийн сүлжээг бий болгоход Улаанбаатар хотын захиргаанд дэмжлэг үзүүлэх юм. Уг төлөвлөгөөнд шат дараатай хөрөнгө оруулалт, хотын шинэчлэл, чадавхийг бэхжүүлэх (бодлого, төлөвлөлт, хяналт шинжилгээ) асуудал хамаарна. Ерөнхий төлөвлөгөөнд дараах 4 стратегийн зорилтыг дэвшүүлэв:

- (i) Стратегийн зорилт 1: дэд төвүүдэд авто зам болон хотын дэд бүтцийн суурь үйлчилгээ (ус хангамж, ариутгах татуурга, дулаан хангамж)-г өргөжүүлэн, тэдгээрийн хоорондын холболтыг сайжруулснаар хотын орон зайн хэв шинжийн өөрчлөлтийг эхлүүлэх;
- (ii) Стратегийн зорилт 2: хүн амын хэрэгцээг хангах, хотын чиг үүрэг, төвшлийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох зорилгоор нийгэм, эдийн засгийн байгууламжид хөрөнгө оруулалт хийснээр эдийн засгийн болон төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;
- (iii) Стратегийн зорилт 3: ус хангамж, ариутгах татуурга, дулаан хангамжийн үйлчилгээг сайжруулснаар үйлчилгээний байгууллагуудын үр ашгийг дээшлүүлэх;
- (iv) Стратегийн зорилт 4: хот төлөвлөлтийг сайжруулж, дэд төвүүдийн хөгжлийг нэмэгдүүлэх, дэд төвийн бүтээн байгуулалтын талаарх иргэдийн ойлголтыг төлөвшүүлэх, тэдний оролцоог хангах, дэд бүтцийн үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаа, менежментийг сайжруулах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадавхийг дээшлүүлэх замаар институцийг бэхжүүлж, чадавхижуулах.

## B. Стратегийн агуулга

5. Улсын Их Хурлаас 2013 оны 2 дугаар сард "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг"-ийг баталсан. Шинэ ерөнхий төлөвлөгөө хоёр чухал үр дүнг авчирсан нь: (i) гэр хорооллын хөгжлийн асуудлыг анх удаа хотын ерөнхий төлөвлөгөөнд тусган уялдуулж өгсөн; (ii) гэр хороолол дахь дэд төвүүдийн үнэ цэнэ, үүргийг хотын ирээдүйн өсөлт хөгжлийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг хэмээн хүлээн зөвшөөрсөн явдал юм. Хотын гэр хорооллын хойд чанадад байрлалтай Баянхошуу болон Сэлбэ дэд төвийг сайжруулахад нэн тэргүүнд анхаарна. Улаанбаатар хотын захиргаа нь хөгжлийн зориулалтаар олгож буй тусламж дэмжлэгээ энэхүү шинэ чиглэлд зориулахыг хөгжлийн түншүүдээсээ хүссэн болно. Улаанбаатар хотын захиргаа Гэр хорооллыг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулж байгаа бөгөөд 2013 оны 3 дугаар сард Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар ахлуулсан Хөтөлбөрийн удирдах хороог байгуулсан. Улаанбаатар хотын захиргаа гэр хорооллын дахин төлөвлөлтийн асуудлыг хариуцах Гэр хорооллыг хөгжүүлэх газар (ГХХГ)-ыг Нийслэлийн Засаг даргын хот байгуулалт, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан орлогчийн удирдлага дор байгуулсан. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2013 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 10/38 тоот тогтоолоороо хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Төсөл 1-д хамрагдах дэд төвүүдийн байршил, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хотын ерөнхий төлөвлөгөөнд уялдуулан зохицуулах чиглэлийг тус тус баталсан. Түүнчлэн Улаанбаатар хотын захиргаа сонгож авсан дэд төвүүдийн дахин төлөвлөлтийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хянах, уялдуулан зохицуулах үүрэгтэй Дэд төвийн дахин төлөвлөлтийн газар хэмээн урьдчилсан байдлаар нэрийдсэн тусгай чиг үүрэг бүхий бүтцийг байгуулахыг санал болгов.

Уг үсэг /Signature/ .....

2019 оны 1 сарын 2-нд  
Улаанбаатар хот

8

Ministry of Foreign Affairs of Mongolia  
OFFICIAL TRANSLATION

6. Хөтөлбөрийг үндэсний хэмжээнд Үндэсний хөгжлийн цогц бодлого, "Шинэ бүтээн байгуулалт" Дунд хугацааны зорилтот хөтөлбөр (2008–2016)-ийн хүрээнд хэрэгжүүлнэ. Улаанбаатар хотын авто замын нөхцлийг сайжруулахаар Эдийн засгийн хөгжлийн яамнаас санаачилсан "Гудамж" төслийн хүрээнд хэрэгжих гэр хорооллын бүрэлдэхүүн хэсгийн бэлтгэл ажил хийгдэж байна. Хөтөлбөр нь АХБ-ны Хот суурины үйл ажиллагааны төлөвлөгөөний<sup>8</sup> зорилт болон АХБ-ны 2020 он хүртэлх стратегитэй<sup>9</sup> уялдсан улсын түншлэлийн стратегитэй<sup>10</sup> тус тус нийцэж байгаа юм.

### С. Бодлогын хүрээ

7. Бодлогын яриа хэлэлцээ явуулах, чадавхийг хөгжүүлэх. Бодлогын хүрээг бэхжүүлэх үүднээс бодлогын яриа хэлэлцээ явуулах, чадавхийг хөгжүүлэх зорилт нь дараахь асуудалд чиглэнэ:

- (i) оршин суугчдын түвшинд тэдний ойлголтыг төлөвшүүлэх, оролцоог хангахад<sup>11</sup> чиглэх ба үүний дотор (a) нийгмийн болон жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх; (b) оршин суугчдын хөгжлийн зөвлөл (ОСХЗ) болон жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ)-ийг дэмжих зөвлөлийг байгуулах; (c) зорилтот хэсгүүдэд зориулсан газар ашиглалтын төлөвлөгөө, орон нутгийг хөгжүүлэх төлөвлөгөө болон зорилтот хэсгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулахад зөвшилцлийг бүрдүүлэх, дэмжих;
- (ii) орон нутгийн түвшинд дэд төвийг хөгжүүлэхэд чиглэх ба үүнд (a) дэд төвийн дахин төлөвлөлтийн газрыг байгуулж, ажиллуулах тухай техникийн удирдамж чиглэл, (b) орон нутгийг хөгжүүлэх төлөвлөгөө, хотын бүсчлэлийн дүрэм журам, барилгын норм стандартыг боловсруулж хэрэгжүүлэх үүднээс институцийн шинэчлэл, зохицуулалт хийх, (c) газрын дахин төлөвлөлт хийх үйл явц дахь олон нийт болон төр, хувийн хэвшлийн хоорондын харилцааг зохицуулах ил тод механизм бүхий хөгжлийн орчин хүрээг бий болгох;
- (iii) хотын ерөнхий төлөвлөгөөний түвшинд, чадавхийг бэхжүүлэх чиглэлээр хэрэгжиж буй АХБ-ны техник туслалцааны хүрээнд Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газар болон Нийслэлийн зураг төслийн хүрээлэнгийн хот төлөвлөлтийн чадавхийг бэхжүүлэх.

8. Ус хангамж, бохир усны үйлчилгээний байгууллагуудын чадавхийг хөгжүүлэх зорилт дараахь асуудалд чиглэнэ. Үүнд: (i) Улаанбаатар хотын захиргаа, УСУГ хооронд байгуулсан менежментийн гэрээг боловсронгуй болгох, (ii) зардлыг нөхөх хэмжээнд үнэ тарифыг тогтоох тодорхой зураглалыг гаргах ба ингэхдээ төлбөрийн чадварын асуудлыг шийдвэрлэх, (iii) үнэ тариф тогтоох, үйлчилгээний чанарт хяналт-шинжилгээ хийж чанарыг хангуулах, тусгай зөвшөөрөл олгох, олон нийтэд хүрч ажиллах чиглэлээр Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлд техникийн туслалцаа үзүүлэх зэрэг болно. Дулааны салбарын шинэчлэл нь сонгосон дэд төвүүдэд ашиглагдаж байгаа болон шинээр ашиглалтанд оруулах дулааны байгууламжийн үйлчилгээ эрхлэгчдийн санхүүгийн тогтвортой байдал, чадавхийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ. Хөтөлбөр нь байгаль орчинд ээлтэй сүүлийн үеийн технологи бүхий хийн түлшээр ажилладаг халаалтын системийг хөгжүүлэх чиглэлээрх Засгийн газрын тэргүүлэх

<sup>8</sup> АХБ. 2013. Хот суурины үйл ажиллагааны төлөвлөгөө 2012–2020. Майилагын Гаднад харилцан гэрээ, лам

<sup>9</sup> АХБ. 2012. Монгол Улстай хамтран хэрэгжүүлэх түншлэлийн стратеги 2012–2016. Манилбулга мөн

<sup>10</sup> АХБ. 2008. Стратеги 2020: АХБ-ны урт хугацааны стратегийн хамрах хүрээ, 2008–2020. Манила

<sup>11</sup> 2012 оны 10 дугаар сард UN-Habitat байгууллага 1 дүгээр үе шатны төслийн дэд төвүүдэд гэр хорооллыг хөгжүүлэхэд олон нийтийн оролцоог танилцуулж зөвлөлдөх уулзалтыг хийсэн signature / *[Signature]*

2014 оны 2 сарын 26-д  
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia  
OFFICIAL TRANSLATION

зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Тэрчлэн хөтөлбөр нь менежментийн гэрээний заалтыг чангатгаж, холбогдох үйл ажиллагааг Эрчим хүчний зохицуулах хорооны үйл ажиллагаатай уялдуулах юм.

9. Санхүүжилтийн хэлбэр. Оршин суугчдын оролцоог хангасан, амьдрах таатай орчин бүрдүүлсэн гэр хорооллын тогтвортой, хөгжлийг дэмжих чиглэлээр АХБ болон Засгийн газар, Улаанбаатар хотын захиргаа хоорондын урт хугацааны түншлэлийн харилцааг дэмжих санхүүжилтийн санал болгож буй хэлбэр нь ОШСЗШ байна. ОШСЗШ нь гэр хорооллыг дахин төлөвлөж хөгжүүлэх бодлогын хүрээнд дэмжлэг үзүүлэх агаад хот төлөвлөлт, бодлогын шинэчлэл, биет болон биет бус хөрөнгө оруулалтын талаар бүтээлч яриа хэлэлцээг өрнүүлэх боломжийг олгоно. ОШСЗШ нь гэр хорооллын нийтийн аж ахуйн суурь үйлчилгээний хамгийн чухал багцуудыг байгуулж, тэдгээрийн ирээдүйн тодорхой, тогтвортой байдлыг хангах бөгөөд Улаанбаатар хотын захиргааны эрэлт хэрэгцээнд нийцсэн дэмжлэгийг АХБ-ны зүгээс үзүүлэх боломжийг бүрдүүлнэ.

10. Хөгжлийн хамтын ажиллагааны зохицуулалт. АХБ нь энэхүү хөтөлбөрийг бэлтгэх явцдаа Улаанбаатар хотын хот байгуулалтын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа Европын хөрөнгө оруулалтын банк, Германы олон улсын хамтын ажиллагааны байгууллага, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага, НҮБ-ХАБИТАТ, АНУ-ын Мянганы сорилтын сан, Дэлхийн банк зэрэг хөгжлийн түншүүдтэй нягт уялдаатай ажиллав. Уг хөтөлбөр нь АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй дараахь гурван хөтөлбөрийн шууд дэмжлэгтэй хэрэгжинэ. Үүнд: (i) хотын төвөөс Сэлбэ дэд төв хүртэл баригдах тусгай замын автобусны шугам<sup>12</sup>, (ii) хөтөлбөрийн зорилтот гэр хорооллуудад орон сууцны, бичил зээлийн, жижиг, дунд үйлдвэрлэлийн санхүүжилт зэрэг дэмжлэг үзүүлэх зээлийн төсөл<sup>14</sup>; (iii) Улаанбаатар хотын захиргааны хот төлөвлөлтийн чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн чадавхи бүрдүүлэх техникийн туслалцаа (тайлбар 12).

#### D. Хөрөнгө оруулалтын хөтөлбөр

11. Хөтөлбөрийн нөлөөллөөр Улаанбаатар хотын амьдрах орчин нөхцөл сайжирсан байна. Үр нөлөөнд нь Улаанбаатар хотын гэр хорооллын бүсэд амьдрах таатай орчин, өрсөлдөх чадвар бүхий тэгш оролцоог хангасан дэд төвүүдийн сүлжээ үүснэ.

12. Хөтөлбөрөөс үндсэн 4 үр дүн гарна: (i) тэргүүлэх ач холбогдол бүхий дэд төвүүдэд авто зам болон хотын дэд бүтцийн үйлчилгээ өргөжиж, тэдгээрийн хоорондын холболт сайжирна; (ii) зорилтот хэсгүүд дэх эдийн засгийн болон төрийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ; (iii) дэд бүтцийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааны үр дүн сайжирна; (iv) хот байгуулалт, хөтөлбөрийн менежмент, үйлчилгээг хүргэх чиглэлээр институци болон чадавхи бэхжинэ. Хөтөлбөрийн биет хөрөнгө оруулалтыг үр дүн (i) - (iii)-ийг, биет бус хөрөнгө оруулалтыг үр дүн (iv)-ийг хэрэгжүүлэхэд зориулна. Хөтөлбөр гурван шатлалаар хэрэгжинэ.

<sup>12</sup> АХБ. 2013. Ядуурлыг бууруулах Японы сангаас санхүүжүүлсэн Улаанбаатар хотын хот байгуулалтын чадавхийг сайжруулах техникийн туслалцаа. Манила.

<sup>13</sup> Хотын тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөрт зориулан Монгол Улсад олгох зээлийн асуудлаар АХБ-ны Ерөнхийлөгчөөс Захирлуудын зөвлөлд хүргүүлэх тайлан-зөвлөмж, АХБ-2012, Манила (Case 2934/2935-MON, 2012 оны 9 сард батлагдсан).

<sup>14</sup> Хувийн хэвшлийн үйл ажиллагааны газраас Тэнгэр группэд зээд олгох 47930 дугаартай төсөл. Зээлийн зарим хэсгийг Хасбанкинд дамжуулан зээлдүүлнэ. Хөтөлбөрт хамрагдах гэр хороололд урьдчилсан тооцоогоор 6.0–10.0 орчим сая ам.долларыг зориулах боломжтой.

Гарын үсэг /Signature/ .....  
2017 оны 1 сарын 21 өдөр  
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia  
OFFICIAL TRANSLATION

13. Төсөл 1. ОШСЗШ-ын эхний шатлалын хүрээнд Сэлбэ, Баянхошуу дэд төвийг хөгжүүлэх чиглэлээр хотын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Үүнд: (i) бохир ус зайлуулах гол коллектор шугамын 6.1 км өргөтгөл, ариутгах татуургын шугамын 2.9 км өргөтгөл; (ii) дэд төвүүдэд тэргүүн ээлжинд баригдах 15 км авто зам, цэвэр усны 18.6 км шугам, ариутгах татуургын 20 км шугам, төвлөрсөн дулаан хангамжийн 21 км шугам, байгаль орчинд ээлтэй сүүлийн үеийн технологи бүхий халаалтын 5 байгууламж; (iii) нийгэм, эдийн засгийн байгууламжууд, үүнд: (a) хүүхдийн 2 цэцэрлэг, ногоон байгууламж, (b) дэд төвийн мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн 2 төв, тэдгээрийг түшиглэн байгуулах бизнесийн 2 инкубатор; (iv) УСУГ-т үзүүлэх олон талт дэмжлэгийн хүрээнд түүний үйл ажиллагааны болон ус хангамж, бохир ус татан зайлуулах үйлчилгээний үр ашгийг дээшлүүлэх; (v) институцийг хөгжүүлэх, чадавхийг бэхжүүлэх дэмжлэгийг: (a) нарийвчилсан зураг төсөл боловсруулах, барилгын ажилд хяналт тавих, (b) оршин суугчдын оролцоог дэмжих, тэдний ойлголтыг төлөвшүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх; (c) дэд төвүүдийг дахин төлөвлөж хөгжүүлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох; (d) Хөтөлбөрийг удирдах алба (ХУА)-ны чадавхийг бэхжүүлэх; (e) дэд бүтцийн үйлчилгээний байгууллагуудын шинэчлэлийг дэмжих чиглэлээр тус тус үзүүлнэ.

14. Төсөл 2 ба Төсөл 3. Санхүүжилтийн бусад шатлалуудын хүрээнд (i) Төсөл 1-д хамрагдсан дэд төвүүдэд хийгдсэн хөрөнгө оруулалтын хамрах хүрээг өргөжүүлж, хотын гэр хорооллын хойд болон зүүн чанад дахь бусад гэр хорооллын дэд төвүүдийг хамруулж, (ii) зорилтот дэд төвүүдийн хоорондын авто замын холболтыг сайжруулна. Төсөл 2-ын зорилтын хүрээнд урьдчилсан байдлаар Ханын материал, Дэнжийн 1000 орчмын дэд төвүүдийг хамруулахаар тооцсон. Төсөл 3-ын зорилтот гэр хорооллоор Улиастай болон Амгалан дахь дэд төвүүдийг урьдчилсан байдлаар авч үзэж байна. Түүнчлэн бусад дэд төвийг хамруулахаар авч үзэж болно. Хоёр болон гуравдугаар үе шатны төслөөр боловсруулах халаалтын шийдлийг сонгохдоо зохистой судалгаан дээр үндэслэн хийн түлшээр ажилладаг байгаль орчинд ээлтэй сүүлийн үеийн технологийг нэн тэргүүнд авч үзнэ.

МОНГОЛ УЛСЫН ГАРЫН ХАРИЛЦАГЧИЙН  
АМБАН АСНЫ ОРЧУУЛГА МОН

МОНГОЛ УЛСЫН ГАРЫН ХАРИЛЦАГЧИЙН

2012 оны 11 сарын 24 өдөр  
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia  
OFFICIAL TRANSMISSION

**Е. Санхүүжилтийн төлөвлөгөө**

15. Хөтөлбөрийн Санхүүжилтийн төлөвлөгөөг дор тоймлон үзүүлэв.

Эх үүсвэр	Хэмжээ (сая ам.дол.)	Нийт дүнд эзлэх хувь (%)
<b>Хөрөнгө оруулалтын хөтөлбөр</b>		
Азийн хөгжлийн банк ОШСЗШ	163.70	51.20
Улаанбаатар хотын захиргаа	96.00	30.00
Хамтарсан санхүүжилт <sup>а</sup>	60.30	18.80
<b>Дүн</b>	<b>320.00</b>	<b>100.00</b>
<b>Төсөл 1</b>		
Азийн хөгжлийн банк		
АХС-ийн зээл	22.50	21.50
ЕСЭҮ-ийн зээл	27.50	26.30
ХБОДБС - ХСТС <sup>б</sup> -ийн буцалтгүй тусламж	3.70	3.50
<b>Хэсгийн дүн АХБ</b>	<b>53.70</b>	<b>51.30</b>
Улаанбаатар хотын захиргаа	22.44	21.50
Хамтарсан санхүүжилт	28.38	27.25
<b>Дүн</b>	<b>104.52</b>	<b>100.00</b>

АХБ = Азийн хөгжлийн банк, АХС = Азийн хөгжлийн сан, ОШСЗШ = Олон шатлалт санхүүжилтийн зээлийн шугам, ЕСЭҮ = Ердийн сангийн эх үүсвэр, ХБОДБС = Хотын байгаль орчны дэд бүтцийн сан


Тайлбар: Дүнг бүхэлдэж авсан учир нийлбэр дүнтэй яв цав тохирохгүй байж болно.

<sup>а</sup> Европын хөрөнгө оруулалтын банкуус хангамж, ариун цэврийн байгууламжид зориулан 60.30 сая хүртэл ам.доллартай тэнцэх хэмжээний зэрэгцээ санхүүжилтийг (АХБ захиран зарцуулахгүй) ОШСЗШ-д оруулах, үүний дотор Төсөлд 1-д зориулан 28.38 сая ам.доллартай тэнцэх хэмжээний санхүүжилт олгох сонирхлоо илэрхийлсэн. Хэрэв ЕХОБ-ны хамтарсан санхүүжилт төлөвлөсний дагуу хэрэгжихгүй нөхцөлд Засгийн газар санхүүжилтийн дутууг тохирох санхүүжилтээр орлуулахад шаардлагатай арга хэмжээг авна

<sup>б</sup> ХБОДБС = Хотын санхүүжилтийн түншлэлийн сангийн Хотын байгаль орчны дэд бүтцийн сан.

<sup>с</sup> Үүнд зөвхөн 1-р үе шатны төслийн дотоодын татвар ба хураамжийн зардал багтсан бөгөөд эдгээр татвар хураамжийг Засгийн газар чөлөөлөх замаар хариуцна

Эх сурвалж: Азийн хөгжлийн банкны хийсэн тооцоо.



ХУВААРЬ 2


ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭ

Төлөвлөлтийн хураангуй	Гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтүүд ба суурь үзүүлэлтүүд	Мэдээллийн эх сурвалж/тайлагнах механизм	Урьдчилсан нөхцөл ба эрсдэлүүд
Нөлөөлөл			
Улаанбаатар хотод амьдрах орчин нөхцөл сайжирна.	<p>2028 он гэхэд: Ядуурлын түвшин 30%-иар буурна (суурь үзүүлэлт: 2012 онд 23.5% байсан)</p> <p>Усаар дамжин халдварладаг халдварт өвчин 30%-иар буурна (суурь үзүүлэлт: 2012 онд 90,310 тохиолдол бүртгэгдсэн)</p> <p>Улаанбаатар хотын агаарын бохирдол 30%-иар буурна (суурь үзүүлэлт: 2012 онд PM<sub>10</sub> 1.286 агууламжтай байсан)</p>	<p>ҮСХ-ны тайлан эмхтгэл</p> <p>Монгол Улсын Засгийн газраас гаргасан нийгмийн эрүүл мэндийн статистик</p> <p>ҮСХ-ны тайлан эмхтгэл</p>	<p>Урьдчилсан нөхцөл Хот байгуулалтыг бодлогоор дэмжиж, хотын дэд бүтцийн хөрөнгө оруулалт нэмэгдэх.</p> <p>Эрсдэл Санхүүгийн болон улс төрийн хүчин зүйлээс хамаарч хотын дэд бүтцийн хөрөнгө оруулалт хязгаарлагдах.</p>
Үр нөлөө			
Улаанбаатар хотын гэр хороололд амьдрах таатай орчин бүхий, өрсөлдөх чадвартай, оршин суугчдын оролцоог хангасан дэд төвүүдийн сүлжээг бий болгох.	<p>2024 он гэхэд: Ус хангамж, ариун цэвэр, халаалтын сайжруулсан үйлчилгээнд хамрагдсан хүн амын тоо 50%-иар өснө (суурь үзүүлэлт: 2012 онд ус хангамж 0%, ариутгах татуурга 0%, халаалт 0%)</p> <p>Зорилтот дэд төвүүдийн нягтрал га тутамд 120 хүн болж нэмэгдэнэ. (суурь үзүүлэлтийн дундаж: 2010 онд га тутамд 50 хүн)</p> <p>Зорилтот дэд төвүүд дэх бизнесийн аж ахуйн нэгжийн тоо 30%-иар нэмэгдэнэ. (суурь үзүүлэлтийн дундаж: 2012 онд 33,140)</p> <p>Усны боловсруулалтын зардал 50%-иар буурна. (суурь үзүүлэлт: 2011 онд 59,400 төгрөг)</p>	<p>Хотын барилгажилтын талаарх УБХЗ-ны тайлан, дүүргүүдийн бүртгэл мэдээ.</p> <p>Хотын барилгажилтын талаарх УБХЗ-ны тайлан, дүүргүүдийн бүртгэл мэдээ.</p> <p>Хотын барилгажилтын талаарх УБХЗ-ны тайлан, дүүргүүдийн бүртгэл мэдээ.</p> <p>УСУГ-ын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан</p>	<p>Урьдчилсан нөхцөл Хотын үйлчилгээ болон засаглалыг сайжруулснаар гэр хорооллын эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах.</p> <p>Эрсдэл Оршин суугчдын оролцоог хангахад цаг хугацаа болон нөөц хангалтгүй байх.</p> <p>Хувийн хэвшлийнхний оролцоо хангалтгүй байх.</p>
Үр дүн			
1. Зорилтот дэд	2016 он гэхэд:		<p>Урьдчилсан нөхцөл 2016 оны 7. сарын 15 өдөр Улаанбаатар хот</p>

МОНГОЛ УЛСЫН ГЭР ХОРООЛД ХОРИЛЦАВИЙН ЯЛМ  
УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛД ХОРИЛЦАВИЙН ЯЛМ  
СЭВИЙ ОРЧУУЛГА МОН

Ministry of Foreign Affairs of Mongolia  
GENERAL TRANSLATION

<p>төвүүдэд зам болон хотын дэд бүтцийн үйлчилгээ өргөжиж, дэд төвүүд хоорондын холболт сайжирна.</p>	<p>18.6 км цэвэр усны шугам сүлжээ, ариутгах татуургын 20.0 км шугам сүлжээ, 6.0 км бохирын гол коллектор шугам барина.</p> <p>Халаалтын 5 байгууламж, 21 км дулаан дамжуулах шугам, 2.4 км урт дулааны холболтын шугам баригдана.</p> <p>15 км авто зам, 7.9 га-д ландшафтын тохижилт хийх, үүний дотор явган зам, гэрэлтүүлэг, сандал зэрэг нийтийн зориулалттай байгууламж барих.</p> <p>2023 он гэхэд: 6 дэд төвд 132 га талбайд ус хангамж, ариутгах татуурга, хотын зам, дулааны шугам сүлжээ барина. (суурь үзүүлэлт: 2012 онд 0 байсан)</p> <p>14.8 км холбох замыг засч сайжруулан, 9.5 км холбох замыг шинээр барина. (суурь үзүүлэлт: 2012 онд 0 байсан)</p>	<p>ХУА-ны явцын болон төгсгөлийн тайлан.</p>	<p>АХБ-ны Хамгаалалтын арга хэмжээний бодлого журмын шаардлагыг УБХЗ хангаж ажиллах.</p> <p>Эрсдэл Эрчим хүч, барилгын материалын дэлхийн зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч хөтөлбөрийн хөрөнгө оруулалт, ашиглалт, засвар үйлчилгээний зардал үлэмж нэмэгдэх.</p>
---	---	--	---



<p>2. Дэд төвийн эдийн засгийн болон нийгмийн дэд бүтцийн үйлчилгээ нэмэгдэнэ.</p>	<p>2023 он гэхэд: 5,000-аас доошгүй хүн, үүнээс 50% нь эмэгтэйчүүд мэргэжлийн сургалтад хамрагдана. (суурь үзүүлэлт: 2012 онд 0)</p> <p>Төсөлд хамрагдсан дэд төвүүдэд оршин суугчдын эрэлт хэрэгцээнд үндэслэн баригдсан нийгмийн байгууламжууд боловсон хүчинээр бүрэн хангагдаж үйл ажиллагаагаа эхлэнэ. (суурь үзүүлэлт: 2012 онд 0)</p>	<p>ХУА-ны явцын болон төгсгөлийн тайлан, мөн дүүргүүдийн бүртгэл мэдээлэл.</p>	<p>Урьдчилсан нөхцөл Эдийн засаг, нийгмийн байгууламжуудад хөрөнгө оруулснаар ажлын байр нэмэгдэх.</p> <p>Эрсдэл Мэргэжил сургалтын курсууд хангалтгүй зохион байгуулагдах.</p> <p>Баригдсан худалдаа үйлчилгээний байгууламжууд эрэлт хэрэгцээгүй байх.</p>
<p>3. Дэд бүтцийн үйлчилгээний байгууллагууд илүү үр ашигтай ажиллана.</p>	<p>2023 он гэхэд: Ус хангамжийн шугам сүлжээ, шахуургын системийг сайжруулна.</p> <p>Түгээх шугам сүлжээ оновчтой болно.</p> <p>Үйл ажиллагааны хяналтын төвийг сайжруулж, өргөтгөнө.</p>	<p>УСУГ-ын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан</p> <p>ХУА-ны явцын болон төгсгөлийн тайлан</p>	<p>Урьдчилсан нөхцөл Бодлогын болон институцын шинэчлэлд дэд бүтцийн үйлчилгээний байгууллагууд дэмжиж оролцох.</p> <p>Үйлчлүүлэгчид цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөрөө төлсөөр байх.</p> <p>Эрсдэл Орлогын дутагдлыг нөхөх хангалттай татаасыг УБХЗ санхүүжүүлж чадахгүй байх.</p>
<p>4. Институцийг бэхжүүлж, чадавхийг бүрдүүлэх.</p> <p>4.1 Дэд төвийг дахин төлөвлөж хөгжүүлэх, оршин суугчдын оролцоог хангах.</p>	<p>2023 он гэхэд: Зорилтот дэд төвүүдэд эмэгтэйчүүдийн 40-өөс доошгүй хувийн идэвхтэй оролцоотойгоор зургаан ОШХЗ, ЖДҮХЗ байгуулагдана. (суурь үзүүлэлт: Зөвхөн Баянхошуу, Сэлбэд 2012 онд ОСХЗ-үүд байгуулагдсан)</p> <p>Олон нийттэй зөвлөлдөх замаар дэд төвүүдийн төлөвлөгөөг бүх сонирхлын бүлгүүд, үүний дотор эмэгтэйчүүдийн 50-иас доошгүй хувийн оролцоотойгоор зөвшилцөн, боловсруулж, батлана.</p>	<p>ХУА-ны явцын болон төгсгөлийн тайлангууд.</p> <p>ОШХЗ-ийн тайлангууд</p>	<p>Урьдчилсан нөхцөл: Хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэхэд хот төлөвлөлтийн болон дэд төвийн хөгжлийн аргачлал, хэрэгсэл, холбогдох эрх зүйн орчин бүрдсэн байх.</p> <p>Дэд төвийг дахин төлөвлөж хөгжүүлснээр газар ашиглалт, менежментийн үр ашиг дээшлэх.</p> <p>Эрсдэл Оршин суугчдын болон хувийн хэвшлийн оролцоо хангалтгүйгээс хөтөлбөрийн хэрэгжилт удаашрах.</p> <p>Хөтөлбөрт эмэгтэйчүүдийг үр дүнтэй оролцуулж чадахгүй байх.</p>

Монгол Улсын Гадаад харилцааны яам  
**АЛЕАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН**  
 Сарын үсэг /Signature/ .....  
 20/2 оны 1 сарын 2 өдөр  
 Улаанбаатар хот  
 Ministry of Foreign Affairs of Mongolia  
 OFFICIAL TRANSLATION




<p>4.2 Дэд бүтцийн үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаа, менежмент сайжирна.</p>	<p>2017 он гэхэд: УСУГ санхүү болон хөрөнгийн удирдлагын хувьд хараат бус, бие даасан байна. (суурь үзүүлэлт: УСУГ хараат байдалтай байгаа)</p> <p>Нийтийн ахуйн үйлчилгээний тарифыг ашиглалт, засвар үйлчилгээний шууд зардал, үүний дотор үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг нөхөх хэмжээнд уялдуулан тогтооно. (суурь үзүүлэлт: тариф нь ашиглалт, засвар үйлчилгээний зардлыг нөхөх төдий хэмжээнд байна.)</p> <p>УБХЗ болон дэд бүтцийн үйлчилгээний байгууллагууд хоорондын гүйцэтгэлийн гэрээг шинэчлэн байгуулсан байна.</p>	<p>УСУГ-ын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан</p> <p>УСУГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөө</p>	<p>Урьдчилсан нөхцөл: Бодлогын шинэтгэл нь Засгийн газрын бүрэн дэмжлэгийг авсан байна.</p> <p>Хэрэглэгчдэд зохистой хураамж/тарифыг УБХЗ-наас ногдуулахгүй байх, эсвэл зорилтот хэрэглэгчид түүнийг нь хүлээж авахгүй байх.</p> <p>Эрсдэл Төсөв хөтөлбөрийн хувьд бодлогын болон институцийн шинэчлэлийг дэмжихэд зориулсан хөрөнгө хангалттай хэмжээнд хуваарилагдахгүй байх.</p> <p>Хувийн хэвшлийг татан оролцуулах таатай нөхцөл, урамшуулал дутагдах.</p>
<p>4.3 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадавхи сайжирна.</p>	<p>2023 он гэхэд: ХУА бүрэн бэлтгэгдсэн боловсон хүчинтэйгээр, үүнээс 30 хувиас доошгүй эмэгтэй ажилтантайгаар үйл ажиллагаа нь бүрэн жигдэрсэн байна. (суурь үзүүлэлт: 2012 онд 0)</p> <p>Хөтөлбөрийн гүйцэтгэл, хяналт-шинжилгээний тогтолцоо хүйсээр задарсан үзүүлэлттэйгээр хэрэгжилт нь жигдэрсэн байна. (суурь үзүүлэлт: 2012 онд 0)</p> <p>Хөтөлбөрт хамрагдсан дэд төвүүдэд хэрэгжих төслийн техник-эдийн засгийн үндэслэл, урьдчилсан үнэлгээнүүд, хамгаалалтын арга хэмжээ боловсруулагдсан байна. (суурь үзүүлэлт: 2012 онд 0)</p>	<p>УБХЗ-ны тайлангууд.</p> <p>ХУА-ны явцын болон төгсгөлийн тайлангууд.</p>	<p>Урьдчилсан нөхцөл: ХУА-ны зөвлөхүүд болон ажилтнууд хамтран нэг баг болж үр дүнтэй ажиллах.</p> <p>Эрсдэл Чадварлаг, туршлагатай зөвлөхүүдээ тогтвортой ажиллуулж чадахгүй байх.</p>

Монгол Улсын Гадаад харилцааны яам  
**АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН**  
 Сарын үсэг /Signature/ .....  
 2014 оны 1 сарын 20 өдөр  
 Улаанбаатар хот  
 Ministry of Foreign Affairs of Mongolia  
**OFFICIAL TRANSLATION**

Үе шат 1-ийн үйл ажиллагаа, түүний төлөвлөгөөт хугацаа (Зээл хүчин төгөлдөр болсны дараа)	Орц
<p>1. Зам болон дэд бүтцийн үйлчилгээг тэлэх</p> <p>1.1 Цэвэр, бохир усны шугам сүлжээг сайжруулах нарийвчилсан зураг төслийг 2014 оны 4-р сард багтаан боловсруулж дуусах.</p> <p>1.2 Дулааны шугам сүлжээг сайжруулах нарийвчилсан зураг төслийг 2014 оны 4-р сард багтаан боловсруулж дуусах.</p> <p>1.3 Зам, бусад дэд бүтцийг сайжруулах нарийвчилсан зураг төслийг 2014 оны 4-р сард багтаан боловсруулж дуусах.</p> <p>1.4 Хотын дэд бүтцийг 2014 оны 4-р сараас 2016 оны хооронд барьж, ашиглалтанд оруулж, ажиллуулж эхлэх.</p> <p>2. Дэд төвүүд дэх эдийн засаг, нийгмийн үйлчилгээг нэмэгдүүлэх</p> <p>2.1 Хүүхдийн цэцэрлэг, бизнесийн инкубатор, мэргэжил сургалтын төвүүдийн нарийвчилсан зураг төслийг 2014 оны дунд гэхэд боловсруулж дууссан байх.</p> <p>2.2 Дээрх барилга байгууламжуудыг 2014 оны дундаас 2017 оны хооронд барьж дуусган, ашиглалтанд оруулж, ажиллуулж эхлэх.</p> <p>3. Дэд бүтцийн үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааны үр ашиг дээшлэх</p> <p>3.1 Үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэхэд үзүүлэх дэмжлэг</p> <p>3.2 Сайжруулсан барилга байгууламж, хэмжилтийн системийг барьж дуусгах</p> <p>4. Институцийг бэхжүүлж, чадавхийг сайжруулах</p> <p>4.1 2013 оны 12 сарын дунд гэхэд ХУА боловсон хүчнээр бүрэн хангагдсан байх.</p> <p>4.2 2014 оны 1 сар гэхэд чадавхийг хөгжүүлэх зөвлөхүүдийг авч ажиллуулах.</p> <p>4.3 2014 оны 12 сар гэхэд дэд төвүүдийн төлөвлөлт, хөгжлийн заавар, журам бэлэн болсон байх.</p> <p>4.4 2014 оны дунд гэхэд зорилтот дэд төвүүд дэх ОШХЗ, ЖДҮХЗ-үүдийн үйл ажиллагаа бүрэн жигдэрсэн байх.</p> <p>4.5 2015 оны дунд гэхэд эрх зүйн орчин, институцийн тогтолцоог сайжруулж, санхүүгийн хувьд бэхжүүлэх дэмжлэг үзүүлсэн байх.</p> <p>Үе шат 2-ыг 2016 он гэхэд боловсруулж батлуулах.</p> <p>Үе шат 3-ыг 2017 он гэхэд боловсруулж батлуулах.</p>	<p>Дүн (сая ам. доллар)</p> <p>Хөрөнгө оруулалтын хөтөлбөр АХБ-ны ОШСЗШ150.00 УБЗ 96.00 Хамтарсан Санхүүжилт 60.30 Нийт 320.00</p> <p>Төсөл 1 АХБ АХС-ийн зээл 22.50 ЕСЭҮ-ийн зээл 27.50 ХБОДБС-ХСТС*3.70 УБХЗ 22.44 Хамтарсан санхүүжилт 28.38 Нийт дүн104.52</p>

АХБ=Азийн хөгжлийн банк; АХС=Азийн хөгжлийн сан; ОШХЗ=Оршин суугчдын хөгжлийн зөвлөл; га=гектар, км=километр, ОШСЗШ=Олон шатлалт санхүүжилтийн зээлийн шугам, УБХЗ=Улаанбаатар хотын захиргаа; ЕСЭҮ=Ердийн сангийн эх үүсвэр, АЗҮ=ашиглалт, засвар үйлчилгээ; ХУА=Хөтөлбөрийн удирдах хороо, ЖДҮХЗ=Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн зөвлөл, УСУГ=Ус сувгийн удирдах газар.  
\*Хотын санхүүжилтийн түншлэлийн сангийн Хотын байгаль орчны дэд бүтцийн сан



## ХУВААРЬ 3

### ХЭРЭГЖИЛТИЙН ХҮРЭЭ

1. Зээлийн шугамын хүрээнд зээлийн хэлэлцээрт өөрчлөлт, нэмэлт орсноос бусад тохиолдолд хөтөлбөрийг дараахь байдлаар хэрэгжүүлнэ:

#### А. Хөтөлбөрийн менежмент

2. Хөтөлбөрийн гүйцэтгэгч байгууллага нь Улаанбаатар хотын захиргаа (УБХЗ) байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийн зохицуулалтыг УБХЗ-ын Хот байгуулалт, хөрөнгө оруулалтын газар хариуцна. Хөтөлбөрийн удирдах алба (ХУА)-ыг Захирагчийн ажлын албаны даргын харьяанд байгуулсан бөгөөд Нийслэлийн хот байгуулалт, хөрөнгө оруулалтын газарт шилжүүлнэ. ХУА-ны захирлаар Нийслэлийн Засаг даргын Хот байгуулалт, хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн орлогч ажиллана. ХУА-ыг 2013 оны 12 сарын дунд үе гэхэд бүрэн бүрэлдэхүүнтэйгээр<sup>13</sup> үйл ажиллагааг нь эхлүүлнэ.

3. Хөтөлбөрийн удирдах хороог байгуулна. Тус хороог Улаанбаатар хотын захирагч ахалж, бүрэлдэхүүнд нь Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Хөдөлмөрийн яам, Эрчим хүчний яам, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Зам, тээврийн яам ба Боловсрол, шинжлэх ухааны яамны төлөөлөл орно. Тус хороо нь хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг стратегийн болон бодлогын удирдамж чиглэлээр хангаж ажиллана.

#### В. Хэрэгжүүлэх хугацаа

4. Хөрөнгө оруулалтын хөтөлбөр 2013 оны 12 дугаар сараас эхлэн 9 хүртэл жилийн хугацаанд хэрэгжинэ. Төсөл 1-ийг 4 жилийн хугацаанд хэрэгжүүлэх бөгөөд 2017 оны 12 дугаар сар гэхэд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөж байна. Дэд бүтцийн ажлуудын бодит гүйцэтгэлийг 2016 онд дуусгахаар тооцож байна. Төсөл 1-ийн зээл, буцалтгүй тусламж хаагдах хугацаа 2018 оны 6 дугаар сарын 31-ний өдөр байна. ОШСЗШ 2023 оны 7 дугаар сарын 31-ний өдөр гэхэд хаагдана.

#### С. Нягтлан бодох бүртгэл, аудит, тайлагнах

5. ХУА/УБХЗ нь санхүүжилт болон гарсан зардлыг санхүүжилтийн эх үүсвэр тус бүрээр дэлгэрэнгүй гаргасан хөтөлбөрийн дансны аудитаар баталгаажсан тайлан болон УБХЗ-ны аудитаар баталгаажсан санхүүгийн жилийн нэгдсэн тайланг жил бүрийн сүүлийн хагаст багтаан АХБ-нд тус тус хүргүүлнэ. Санхүүгийн жилийн нэгдсэн тайланд үндэслэн мөнгөн урьдчилгааны дансны гүйлгээ, зардлын тайлангийн үйл ажиллагааны журам болоод АХБ-ны зээлийн, буцалтгүй тусламжийн ба төслийн хэлэлцээрт тусгагдсан тусгай үүрэг амлалтууд хэрэгжиж байгаа эсэх талаар аудиторын дүгнэлтийг жил бүрийн аудитын тайланд тусгана.

6. Хөтөлбөрийн менежментийн зөвлөхүүд төсөл тус бүрийн явцын тайланг жилд хоёр удаа бэлтгэж, ХУА-аар хянуулан, АХБ-нд хүргүүлэхийн өмнө нэгтгүүлэхээр ХУА/УБХЗ-нд ирүүлнэ. Явцын тайланд ажлын бодит ахиц, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт, ажлын явц байдал, худалдан авалт ба гэрээний явц, хэрэгжилттэй холбоотой аливаа

<sup>13</sup> АХБ-тай тохирсон шалгуурыг хангахуйц мэргэшлийн чадвар бүхий ажилтнуудыг ХУА-нд авч ажиллуулна.  
2017 оны 12 сарын 2 өдөр  
Улаанбаатар хот


чухал асуудлуудын талаар тусгана. Түүнчлэн төслийн данснуудын талаарх хураангуй товчоон, үүний дотор төслийн хамгийн сүүлчийн зардлууд болон гэрээний үнийн дүнг явцын тайланд илтгэнэ. Үүний зэрэгцээ, төслийн хэрэгжилтийн явцын үнэлгээний талаар тусгасан байна. Төсөл тус бүр бодитой хэрэгжиж дууссанаас хойш 6 сарын дотор ХУА/УБХЗ төслийн төгсгөлийн тайланг АХБ-нд хүргүүлэхийн өмнө нэгтгэн бэлтгэх бөгөөд түүнд төслийн хэрэгжилт болон зардлуудын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, гүйцэтгэлийн зорилтуудаа хэр амжилттай биелүүлсэн талаарх үнэлгээг тусгана.

**D. Хөтөлбөрийн гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ**

7. Төслийг бэлтгэх явцад хөтөлбөрийн гүйцэтгэл, менежментийн системийн шалгуур үзүүлэлтүүд, тэдгээрийн хамаарлын талаар Улаанбаатар хотын захиргаатай ярилцаж зөвшилцөв. Хөтөлбөрийн гүйцэтгэлийг түүний нөлөөлөл, гарах үр дүн, үр нөлөөний хувьд үнэлэх багц үзүүлэлтийг Улаанбаатар хотын захиргаа зөвшөөрсөн болно. Хөтөлбөрийн хэрэгжилтийн эхэнд Улаанбаатар хотын захиргаа нь шалгуур үзүүлэлтүүдийн суурь үзүүлэлт, хүрэх зорилтот түвшинг тогтооно. Шалгуур үзүүлэлтийг хөтөлбөрийн эхэн, дунд, төгсгөл үед болон Хөтөлбөр хэрэгжиж дууссанаас хойш 3 жилийн дараа тус тус хэмжиж, суурь үзүүлэлттэй харьцуулна (Хуваарь 2). Өгөгдлийн үндсэн эх сурвалж нь Засгийн газрын эх сурвалжаас авах хоёрдогч мэдээ баримт болон шууд цуглуулах өгөгдлөөс бүрдэнэ. Улаанбаатар хотын захиргаа нь Хөтөлбөрийн эхэн, дунд, төгсгөлд болон Хөтөлбөр хэрэгжиж дууссанаас хойш 3 жилийн дараа тус тус хийсэн хяналт-шинжилгээний гол үр дүнгийн талаарх тайланг АХБ-нд хүргүүлнэ.

**E. Хөтөлбөрийн хяналт**

8. АХБ болон Улаанбаатар хотын захиргаа нь Хөтөлбөрийн институт, захиргаа, техник, эдийн засаг, байгаль орчин, нийгэм, нүүлгэн шилжүүлэлт болон Хөтөлбөрийн гүйцэтгэлд нөлөөлж болохуйц холбогдох бусад асуудлуудыг хамарсан үнэлгээг жил бүр гүйцэтгэнэ. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц зээлийн хэлэлцээрт тусгагдсан үүрэг амлалтуудад хэр нийцэж байгааг уг үнэлгээний хүрээнд нягтлан шалгана.



ХУВААРЬ 4

ТӨСЛҮҮДИЙГ СОНГОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ТӨСЛИЙГ БАТЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

A. Сонгох шалгуур үзүүлэлт

1. Энэхүү Хөтөлбөрийн хүрээнд санхүүжүүлэх төслүүдэд дараахь шалгуур үзүүлэлтүүд тавигдана:

- (i) Төслүүд нь Улаанбаатар хотод байрлах бөгөөд гэр хороолол дахь дэд төвүүд, эсхүл хотын коридорыг дахин төлөвлөж хөгжүүлэх үйл ажиллагаа, эсхүл хотын дэд бүтцийн үйлчилгээний гүйцэтгэл, хүргэлтийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг хамарсан байна.
- (ii) Худалдан авах тоног төхөөрөмж, бараа материал нь үндэсний стандартад нийцсэн байна.
- (iii) Төслүүд нь нийгэмд үзүүлэх нөлөөлөл, эдийн засгийн хөгжлийн хувьд эерэг нөлөө үзүүлэхүйц, техникийн хувьд дэвшилттэй бөгөөд техник, эдийн засгийн үндэслэл тооцоо нь Монгол Улсын Засгийн газар болон АХБ-наас тавьж буй инженерийн, санхүүгийн болон эдийн засгийн шаардлагуудыг хангасан байна.
- (iv) Төслүүдийн эдийн засгийн үнэлгээ хийх тухай АХБ-ны 1997 оны журмын дагуу тооцоолсон эдийн засгийн үнэлгээгээр төслийн эдийн засгийн өгөөжийн дотоод нормын түвшин нь 12% буюу түүнээс дээш байна.
- (v) Төслүүд нь энэхүү Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр (СЕХ)-ийн Хуваарь 5-д тусгагдсан, харилцан тохиролцсон Хамгаалалтын арга хэмжээнд бүрэн нийцсэн байна.
- (vi) Засгийн газраас шаардлагатай бүх зөвшөөрлийг авсан байна.
- (vii) Төслийг хэрэгжүүлж дуусгахад шаардагдах, хангалттай хэмжээний дотоодын санхүүжилтийг төсөвт тусгасан байна.
- (viii) ОШСЗШ-аас санхүүжсэн өмнөх төслийн гүйцэтгэл хангалттай байна.
- (ix) ОШСЗШ-ын салбарын төлөвлөгөөний хэрэгжилт хангалттай байна.

B. Зөвшөөрөл авах журам

2. Энэхүү Зээлийн шугамын хүрээнд хэрэгжих санхүүжилтийн 1 дүгээр шатлалын үнэлгээг хийж эхний Ye шатны санхүүжилтийн хүсэлт (ҮШСХ)-д хамруулсан. Дараа дараачийн санхүүжилтийн шатлалд дараахь журмыг баримтална:

- (i) Улаанбаатар хотын захиргаа төслийг хянаж, тогтоосон сонгох шалгуур үзүүлэлттэй харьцуулж үнэлнэ. Улаанбаатар хотын захиргаа нь төслүүдэд техникийн үнэлгээ хийх асуудлыг хариуцна.
- (ii) Улаанбаатар хотын захиргаа тухайн санхүүжилтийн шатлалын тухай мэдээлэл, үүний дотор Хуваарь 5-д тусгасан хамгаалалтын арга хэмжээний шаардлагын талаарх мэдээллийг хянуулж зөвшөөрөл авахаар АХБ-нд хүргүүлнэ.
- (iii) Улаанбаатар хотын захиргаа Эдийн засгийн хөгжлийн яам (ЭЗХЯ)-аар дамжуулан дараа дараачийн санхүүжилтийн шатлалын үнэлгээний АХБ-нд албан ёсоор хүргүүлнэ.

Арын үсэг /Signature/


2012 оны 7 сарын 26 дөр  
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia  
OFFICIAL TRANSLATION

## ХУВААРЬ 5

### НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ

1. Монгол Улсын Засгийн газар нь энэхүү Хуваарьт тусгагдсан бүх шаардлагууд, Зээлийн шугам болон санхүүжилтийн эхний шатлалд зориулан боловсруулсан нийгмийн болон байгаль орчны хамгаалалтын дор дурдсан арга хэмжээ, төлөвлөгөөг Улаанбаатар хотын захиргаа хангаж ажиллахыг хариуцна. Тэдгээрийн бүрэн эхийн хувийг АХБ-нд хүргүүлэхийн зэрэгцээ энд иш татан оруулсанд тооцох бөгөөд Зээлийн шугамын хүрээнд санхүүжих төслүүдийг боловсруулж, хэрэгжүүлэхэд дагаж мөрдөхийг баталгаажуулна.
  - (i) 2013 оны 7 дугаар сард хийгдсэн байгаль орчны үнэлгээ, хяналтын хүрээ;
  - (ii) 2013 оны 7 дугаар сард хийгдсэн нүүлгэн шилжүүлэлтийн хүрээ;
  - (iii) 2013 оны 10 дугаар сард хийгдсэн санхүүжилтийн эхний шатлалд зориулсан байгаль орчны урьдчилсан үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамт;
  - (iv) 2013 оны 8 дугаар сард хийгдсэн санхүүжилтийн эхний шатлалд зориулсан газар чөлөөлөх болон нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөний төсөл.
2. АХБ-ны хамгаалалтын арга хэмжээний журамд зааснаар дээрх баримт бичгүүдэд Зээлийн шугамтай холбоотой дараахь мэдээлэл болон тавигдах шаардлагуудыг тусгана:
  - (i) Зээлийн шугамаас санхүүжих магадлалтай төслүүд, тэдгээрийн бүрэлдэхүүн хэсгүүдээс байгаль орчин, албадан нүүлгэн шилжүүлэлтэд үзүүлж болзошгүй ерөнхий нөлөөлөл; (ii) урьдчилсан үнэлгээ хийх, зэрэглэл тогтоох, нөлөөллийн үнэлгээ, менежментийн төлөвлөгөө боловсруулах, гомдол барагдуулах механизм, олон нийттэй зөвлөлдөх, мэдээллийг ил тод болгох (байгаль орчны нөлөөллийн үнэлгээ/ анхдагч байгаль орчны үнэлгээ/байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй холбоотой мэдээллийг 120 хоногийн турш нээлттэй байлгах журам хамаарна) болон хяналт-шинжилгээ хийх, тайлагнахтай холбоотой шаардлага, журам; (iii) институцийн зохицуулалт (төсөв, чадавхитай холбоотой шаардлагууд хамаарна), хамгаалалтын арга хэмжээний баримт бичгүүдийг бэлтгэх, хянах, хэрэгжүүлэхтэй холбоотой зээлдэгч болон АХБ-ны бүрэн эрх болон үүрэг хариуцлага.
3. ҮШСХ бүрийг боловсруулахын өмнө Улаанбаатар хотын захиргаа нь байгаль орчны үнэлгээ, албадан нүүлгэн шилжүүлэлттэй холбогдох хамгаалалтын арга хэмжээг хянан үзэх ба үндэсний хууль тогтоомж болон АХБ-ны хамгаалалтын арга хэмжээний талаарх дүрэм, журамд (тухай бүр нэмэлт, өөрчлөлт орсон) нийцүүлэн шинэчилнэ.
4. Зээлдэгч нь шинээр ҮШСХ-ийг боловсруулах тухай бүр одоо хэрэгжиж байгаа төслүүд нийгмийн болон байгаль орчны хамгаалалтын арга хэмжээний төлөвлөгөө, хүрээтэй нийцэж байгаа эсэхийг хянан үзэх бөгөөд хамгаалалтын арга хэмжээний хүрээнд заасны дагуу тэрхүү хяналтын тайланг тухайн санхүүжилтийн шатлалд хамрагдаж буй төсөлтэй холбоотой хамгаалалтын бусад шаардлагатай баримт бичгийн хамт АХБ-нд хүргүүлнэ. Хэрэгжиж буй төслүүдийг хянах явцад томоохон зөрчил илэрсэн тохиолдолд түүнийг залруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж АХБ-нд батлуулахаар хүргүүлнэ.



## ХУВААРЬ 6

### ҮҮРЭГ АМЛАЛТ

1. Зээлийн шугамын хүрээнд хэрэгжих санхүүжилтийн шатлал бүрийн хууль ёсны хэлэлцээрээр АХБ-ны зүгээс шаардах үүрэг амлалтууд болон энэхүү СЕХ, түүний Хуваариудад тусгагдсан үүрэг амлалтуудаас гадна Монгол Улсын Засгийн газар дараахь үүрэг амлалтыг авав:

- (i) Монгол Улсын Засгийн газар болон Улаанбаатар хотын захиргаа нь: (i) Хөтөлбөр, энэхүү СЕХ-ийн Хуваарь 3-т тусгагдсан хэрэгжилтийн зохицуулалт, Хуваарь 2-т тусгагдсан Төлөвлөлт, хяналт шинжилгээний хүрээнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээг цаг хугацаанд нь хэрэгжүүлэх; (ii) энэхүү Зээлийн шугамаас санхүүжих бүх төслүүдийг энэхүү СЕХ-ийн Хуваарь 4-т тусгагдсан шалгуур, журмын дагуу сонгож батлах; (iii) Зээлийн шугамаас санхүүжих бүх төслүүдийг энэхүү СЕХ-ийн Хуваарь 5-д тусгагдсан хамгаалалтын болон нийгмийн шаардлагуудад нийцүүлэн боловсруулах, хэрэгжүүлэх, тогтвортой удирдахыг хариуцна.
- (ii) Монгол Улсын Засгийн газар Зээлийн шугамаас санхүүжих аливаа төслийн эдийн засгийн сөрөх чадварт нөлөөлөхүйц хот байгуулалт болон эдийн засгийн хөгжилтэй холбоотой бүх бодлого, хөтөлбөрийн талаар АХБ-нд тухай бүр мэдээлж байна. Ерөнхий төлөвлөгөө, бодлогын орчин хүрээ, хөтөлбөр, эсхүл санхүүжилтийн төлөвлөгөөнд аливаа өөрчлөлт орох бүрт Монгол Улсын Засгийн газар болон АХБ нь түүний Хөтөлбөрт үзүүлэх нөлөөллийн үнэлгээг хийж, Хөтөлбөрийн үр дүнд гарах аливаа өөрчлөлтийг үнэлнэ.
- (iii) Монгол Улсын Засгийн газар энэхүү СЕХ-ийн Хуваарь 1-д дурдсан хотын дэд бүтцийн үйлчилгээг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг Улаанбаатар хотын захиргаа хэрэгжүүлэхийг хариуцна.
- (iv) Монгол Улсын Засгийн газар нь Улаанбаатар хотын захиргаа Гэр хорооллын дэд төвүүдийг олон нийтийн оролцоотой дахин хөгжүүлэх ажлыг хэрэгжүүлэх байгууллагыг АХБ-ны шаардлагад нийцүүлэн байгуулж ажиллуулах, холбогдох Оршин суугчдын хөгжлийн зөвлөл (ОСХЗ) нь олон нийттэй зохих ёсоор зөвшилцөж байгаа эсэхэд хяналт тавих, хувийн хэвшлийн оролцоог дэмжих, газрыг дахин төлөвлөх ажлыг эрх тэгш зарчмын үндсэн дээр явуулах, газрыг дахин зохион байгуулах, түүнд хамрагдсан иргэдэд зохистой нөхөх олговор олгохтой холбоотой ил тод механизм, уг асуудлыг хариуцах байгууллагын үйл ажиллагааг АХБ-ны шаардлагад нийцүүлэн бүрдүүлэхийг хариуцна.
- (v) Монгол Улсын Засгийн газар нь Төсөл 1-ийн хүрээнд хамарч өртсөн иргэд, оршин суугчид, газрыг дахин зохион байгуулах төсөлд хамрагдсан иргэд, оршин суугчдыг нүүлгэн шилжүүлэхэд зориулсан 40 айлын орон сууцны барилгыг 2014 оны эцсээр дэд төв тус бүрд барихад хүрэлцэхүйц хэмжээний санхүүжилтийг Улаанбаатар хотын захиргаа төсөвтөө тусгах явдлыг хариуцна. Нүүлгэн шилжүүлэхэд зориулсан орон сууц нь чанар, аюулгүй байдал, ерөөний тоо, төлбөрийн чадварт нийцэх байдал, оршин суух нөхцөл, ашиглах боломжийн хувьд төсөлд хамрагдсан иргэдийн хэрэгцээг хангахуйц байна.
- (vi) Монгол Улсын Засгийн газар Хөтөлбөрийг цаг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай дотоодын санхүүжилтийг бэлэн байлгах бөгөөд Хөтөлбөр, төслүүдийн магадлашгүй ажлын зардлаас давсан аливаа зардлыг санхүүжүүлэх нэмэлт санхүүжилтийг хариуцна.

Улаанбаатар хотын захиргаа  
2014 оны 1 сарын 2 /саяр  
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia  
OFFICIAL TRANSLATION